



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/371

Улаанбаатар хот

Шуурхай штабыг сунган ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 01 дүгээр тогтоол, Нийслэлийн засаг даргын 2020 оны “Коронавируст /КОВИД-19/ цар тахлын үед эдийн засгийг дэмжих зарим арга хэмжээний тухай” А/930 дугаар захирамж, 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Б/91 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан, шинэ коронавирус /COVID-19/-ээс урьдчилан сэргийлэх ажил, хяналт шалгалт явуулахтай холбоотой мэдээ, мэдээллийг нэгтгэн дамжуулах, дуудлага, мэдээллийн дагуу ажиллах үүрэг бүхий шуурхай штабыг 2020 оны 07 дугаар сарын 16-ний өдрөөс 07 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар сунган ажиллуулсугай.

2. Шуурхай штабын үйл ажиллагаанд шаардагдах 1,600,000 /нэг сая зургаан зуун мянга/ төгрөгийг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ахлах нягтлан бодогч Б.Хонгорзулд зөвшөөрсүгэй.

3. Штабт ажиллах бүрэлдэхүүний хуваарийг баталж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /хурандаа Б.Сүхбаатар/-т, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа С.Буянжаргал/-т, Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Нарангэрэл/-т тус тус даалгасугай.


4. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /хурандаа Б.Сүхбаатар/-т үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн төвд мэргэжлийн эмч нараас бүрдсэн жижүүрийн бүрэлдэхүүнийг 24 цагаар үүрэг гүйцэтгэхээр томилон, шуурхай штабтай хамтран ажиллаж, өдөр тутмын явцын мэдээ, мэдээллийг штабын 70120318 дугаарын утсанд 14:00, 20:00 цагуудад, нэгдсэн мэдээг 08:00 цагт өгч, өгөгдсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төв /З.Балдандугар/-д даалгасугай.

6. Дүүргийн нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалтаар ажиллаж байгаа бүрэлдэхүүн эргүүлийн нэгдсэн мэдээг 20:00 цагт шуурхай штабт өгч ажиллахыг харьяа хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч Д.Бямбадорж-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Г.НАРАНГЭРЭЛ

Баянгол дүүргийн Засаг даргын
2020 оны 07 дугаар сарын 20 –ны өдрийн
А/371 дугаар захирамжийн хавсралт

ШУУРХАЙ ШТАБЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

2020 оны 07 дугаар сарын 20

Улаанбаатар хот

д/д	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Хоног /тоо ширхэг/	Нийт
1	Хоол /хоногт 4 хүн/	20,000	16x4	1,280,000
2	Шатахуун /хоногт автомашин/ 1	20,000	16	320,000
Нийт дүн				1,600,000